

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам
ТЭДС	Тариалан эрхлэгчдийг дамжих сан
БОТ	Бага оврын трактор
ХХАЯ	Хөдөө аж ахуйн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХХААХҮЯ-НЫ ТАРИАЛАН
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН БАГА ОВРЫН ТРАКТОР
ХУДАЛДАН АВАХ ТӨСЛИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
В.ҮНЭНБАТ ТАНАА

2020.02.27 № 06/635
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны тариалан эрхлэлтийг дэмжих сангийн, хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн захирагч В.Үнэнбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төслийн захирагч санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн даргад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Б энд С аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Д.Заяажаргал, Чанарын хяналтын менежер Э.Дэлгэрцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний 1/10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүнс хөдөө аж ахуйн салбарын бодлогын удирдамж, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг бүрдүүлж хуваарилах замаар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

ХХААЯ /хуучин нэрээр/ болон Сангийн яамны хооронд “Дамжуулан зээлдүүлэх гэрээ” байгуулан БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хадлангийн болон өрхийн газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалттай техник, тоног төхөөрөмж худалдан авахад зориулан 40.0 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр 2 үе шаттайгаар техник, тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.

1 дүгээр ээлжид 27.9 сая ам.долларын үнэ бүхий 3150 ширхэг 20 морины хүчтэй бага оврын трактор, хадуур тармуурын иж бүрдэл, 5250 ширхэг 25 морины хүчтэй бага оврын трактор, анжисны хамт нийт 8400 ширхэг трактор нийлүүлж, уг зээл нь 20 жилийн хугацаатай, жилийн 2 хувийн хүүтэй, эхний 5 жилд үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэйгөөр малчид, тариаланчдад зээлээр олгосон байна.

2 дугаар ээлж буюу 2015 онд 21.1 сая ам.долларын үнэ бүхий 276 ширхэг хөдөө аж ахуйн зориулалтын дунд оврын трактор, түүний чиргүүл, үр тарианы комбайн нийлүүлэгдэж Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 4 дүгээр сарын 2-ны А/46 дугаар тушаалаар зээлийн хүүг жилийн 2 хувиар, үйл ажиллагааны зардлыг 2 хувиар, урьдчилгаа төлбөрийг 20 хувиар тогтоон үлдэх төлбөрийг 5 жилийн хугацаанд тэнцүү төлөх нөхцөлтэй барьцаат зээлийн гэрээгээр худалдсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Ахplorer 3.16” програм хангамж ашигладаг байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,790,515.3 мянган төгрөгөөс тооцон 17,905.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг өөрчлөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,296,218.9 мянган төгрөгөөр буюу 209 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	911,347.4	241,109.5	-670,237.9
Авлага	55,245,560.4	70,447,639.0	15,202,078.6
Урьдчилгаа			
Бараа материал	2,342,125.4	52,107,168.5	49,765,043.1
Үндсэн хөрөнгө	3,395.0	2,730.0	-665.0
Нийт хөрөнгө	58,502,428.2	122,798,647.1	64,296,218.9
Өр төлбөр	100,983,003.6	170,445,039.6	69,462,036.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	(42,480,575.4)	(47,646,392.5)	(5,165,817.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	58,502,428.2	122,798,647.1	64,296,218.9

Авлага дансны үлдэгдэл 15,202,078.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд шинээр техник, тоног төхөөрөмж худалдан авч аж ахуйн нэгж байгууллагуудад эргэн төлөгдөх гэрээтэйгээр худалдсанаас шалтгаалжээ.

Авлага дансны эхний үлдэгдэлд 2012-2018 онуудад үүссэн 55,245,560.4 мянган төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах авлага байна. Энэ нь бага оврын тракторыг анх худалдахдаа барьцаагүй олгосон, сонгуулийн сурталчилгаанд ашиглаж үлдэгдэл төлбөрийг хаасан мэтээр ойлгуулсан нь эргэн төлөлтийг удаашруулсан байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сантай харилцаатай аж ахуй нэгж, иргэд сүүлийн гурван жил дараалан ургац алдсанаас эргэн төлөлт буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд БНХАУ-аас Сангийн яамны дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу шинээр 65,114,195.1 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 69,462,036.0 мянган төгрөгөөр өссөн нь дээрх дамжуулан зээлээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр дансанд БНХАУ-аас Сангийн яамны дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу авсан техник тоног төхөөрөмжийн үнэ 169,875,915.1 мянган төгрөгийн өр байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2012-2019 онуудад үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй 569,124.5 мянган төгрөгийн өр байна. Энэ нь нийт өр төлбөрийн 32.1 хувийг эзэлж байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төслийн зохицуулагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 5 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар 3,808.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүллээ.

1. Томилолтын зардлыг анхан шатны баримтгүй, илүү тооцож 3,808.5 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дугаар заалт " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2018 оны 301 дүгээр тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Говь-Алтай, Архангай, Дархан-Уул, Завхан, Говьсүмбэр зэрэг сумдын 1325 иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгосон бага оврын тракторын үнэ 4,735,367.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгааг ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэл хийхэд аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрууд нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн өр, авлагыг тооцоо нийлж баталгаажуулна гэсэн тайлбар өгсөн тул дараагийн аудитаар дахин шалгаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төсөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 107 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа явж байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөдөө аж ахуйн бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,499,033,185.61	122,795,917,076.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	911,347,377.36	241,109,509.76
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31110	Төгрөг	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	911,347,377.36	241,109,509.76
31210	Төгрөг	911,347,377.36	241,109,509.76
31213	Арилжааны банк дахь харилцах	911,347,377.36	241,109,509.76
33	АВЛАГА	55,245,560,419.46	70,447,639,048.88
33500	Бусад авлага	16,769,721,137.57	20,324,547,752.79
33510	Байгууллагаас авах авлага	16,769,721,137.57	20,324,547,752.79
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	0.00
33600	Зээлийн авлага	38,475,839,281.89	50,123,091,296.09
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	38,475,839,281.89	50,123,091,296.09
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	38,475,839,281.89	50,123,091,296.09
35	БАРАА МАТЕРИАЛ	2,342,125,388.79	52,107,168,518.23
35100	Түүхий эд материал	2,342,125,388.79	52,107,168,518.23
35110	Тусгай зориулалттай материал	2,342,125,388.79	52,107,168,518.23
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,395,000.16	2,730,000.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,395,000.16	2,730,000.24
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	3,395,000.16	2,730,000.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,800,000.00	2,800,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-559,999.92	-839,999.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,925,000.00	1,925,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-769,999.92	-1,154,999.88
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	58,502,428,185.77	122,798,647,077.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	100,983,003,582.45	170,445,039,643.38
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	432,669,178.89	569,124,571.90
41200	Богино хугацаат зээлийн өглөг	432,669,178.89	569,124,571.90
41220	Гадаад валют	432,669,178.89	569,124,571.90
41224	Төслийн зээл	432,669,178.89	569,124,571.90
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,550,334,403.56	169,875,915,071.48
42200	Урт хугацаат зээл	100,550,334,403.56	169,875,915,071.48
42220	Гадаад валют	100,550,334,403.56	169,875,915,071.48
42224	Төслийн зээл	100,550,334,403.56	169,875,915,071.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-42,480,575,396.68	-47,646,392,566.27
51	Засгийн газрын хувь оролцоо	-42,480,575,396.68	-47,646,392,566.27
51200	Хуримтлагдсан үр дүн	-42,480,575,396.68	-47,646,392,566.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-33,693,705,623.44	-42,588,405,596.68
51220	Тайлант үеийн үр дүн	-8,786,869,773.24	-5,057,986,969.59
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	58,502,428,185.77	122,798,647,077.11

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,499,033,185.61	122,795,917,076.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	911,347,377.36	241,109,509.76
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31110	Төгрөг	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	911,347,377.36	241,109,509.76
31210	Төгрөг	911,347,377.36	241,109,509.76
31213	Арилжааны банк дахь харилцах	911,347,377.36	241,109,509.76
33	АВЛАГА	55,245,560,419.46	70,447,639,048.88
33500	Бусад авлага	16,769,721,137.57	20,324,547,752.79
33510	Байгууллагаас авах авлага	16,769,721,137.57	20,324,547,752.79
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	0.00
33600	Зээлийн авлага	38,475,839,281.89	50,123,091,296.09
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	38,475,839,281.89	50,123,091,296.09
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	38,475,839,281.89	50,123,091,296.09
35	БАРАА МАТЕРИАЛ	2,342,125,388.79	52,107,168,518.23
35100	Түүхий эд материал	2,342,125,388.79	52,107,168,518.23
35110	Тусгай зориулалттай материал	2,342,125,388.79	52,107,168,518.23
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,395,000.16	2,730,000.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,395,000.16	2,730,000.24
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	3,395,000.16	2,730,000.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,800,000.00	2,800,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-559,999.92	-839,999.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,925,000.00	1,925,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-769,999.92	-1,154,999.88
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	58,502,428,185.77	122,798,647,077.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	100,983,003,582.45	170,445,039,643.38
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	432,669,178.89	569,124,571.90
41200	Богино хугацаат зээлийн өглөг	432,669,178.89	569,124,571.90
41220	Гадаад валют	432,669,178.89	569,124,571.90
41224	Төслийн зээл	432,669,178.89	569,124,571.90
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,550,334,403.56	169,875,915,071.48
42200	Урт хугацаат зээл	100,550,334,403.56	169,875,915,071.48
42220	Гадаад валют	100,550,334,403.56	169,875,915,071.48
42224	Төслийн зээл	100,550,334,403.56	169,875,915,071.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-42,480,575,396.68	-47,646,392,566.27
51	Засгийн газрын хувь оролцоо	-42,480,575,396.68	-47,646,392,566.27
51200	Хуримтлагдсан үр дүн	-42,480,575,396.68	-47,646,392,566.27
51210	Өмнөх үеийн үр дүн	-33,693,705,623.44	-42,588,405,596.68
51220	Тайлант үеийн үр дүн	-8,786,869,773.24	-5,057,986,969.59
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	58,502,428,185.77	122,798,647,077.11

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,242,132,471.79	1,649,835,371.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,242,132,471.79	1,649,835,371.62
120	Нийтлэг татварын бус орлого	1,242,132,471.79	1,649,835,371.62
120001	Хувьцааны ногдол ашиг	0.00	0.00
120002	Хүүгийн орлого	965,109,497.99	699,010,152.55
120003	Торгуулийн орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	277,022,973.80	950,825,219.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	168,192,773.80	871,127,732.45
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	108,830,200.00	79,697,486.62
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,792,340,450.93	1,790,515,264.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,792,340,450.93	1,790,515,264.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,792,340,450.93	1,790,515,264.77
2107	Томилолт, зочны зардал	1,072,000.00	43,311,320.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,072,000.00	43,311,320.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,786,896,803.65	47,108,027.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,785,052,503.65	34,749,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	12,272,727.27
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,844,300.00	85,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,371,647.28	1,700,095,917.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,706,647.36	1,699,430,917.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	664,999.92	664,999.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-550,207,979.14	-140,679,893.15
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	354,078,454.46
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	354,078,454.46
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,236,661,794.10	5,271,385,530.90
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	8,236,661,794.10	5,271,385,530.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-8,786,869,773.24	-5,057,986,969.59

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,815,542,810.53	2,897,169,444.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,815,542,810.53	2,897,169,444.78
120	Нийтлэг татварын бус орлого	2,815,542,810.53	2,897,169,444.78
120001	Хувьцааны ногдол ашиг	0.00	0.00
120002	Хүүгийн орлого	586,731,539.33	54,630,133.26
120003	Торгуулийн орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,228,811,271.20	2,842,539,311.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,228,811,271.20	61,773,362.85
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,780,765,948.67
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,547,426,836.22	2,507,407,312.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,547,426,836.22	2,507,407,312.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,547,426,836.22	2,507,407,312.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	1,072,000.00	43,311,320.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,072,000.00	43,311,320.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,786,896,803.65	2,271,462,464.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,700,000.00	91,871,934.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	12,272,727.27
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	144,300.00	85,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	1,785,052,503.65	1,726,629,230.70
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	0.00	440,602,872.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,759,458,032.57	192,633,527.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,759,458,032.57	192,633,527.99
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-3,731,884,025.69	389,762,132.40
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	-1,060,000,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	1,060,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	0.00	1,060,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-3,731,884,025.69	-670,237,867.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,643,231,403.05	911,347,377.36
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	911,347,377.36	241,109,509.76
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	0.00	0.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-33,695,546,516.44	-33,695,546,516.44
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,840,893.00	1,840,893.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-33,693,705,623.44	-33,693,705,623.44
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-8,786,869,773.24	-8,786,869,773.24
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-42,480,575,396.68	-42,480,575,396.68
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-42,480,575,396.68	-42,480,575,396.68
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-107,830,200.00	-107,830,200.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-42,588,405,596.68	-42,588,405,596.68
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-5,057,986,969.59	-5,057,986,969.59
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-47,646,392,566.27	-47,646,392,566.27



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 02

№ 02/59

Улаанбаатар хот

СМН 2020/714/СТА.ТХН

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ХХААХҮЯ-ны ТЭДС-гийн ХАА-н бага оврын трактор худалдан авах төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:




Томилолтын зардлыг анхан шатны баримтгүй, илүү тооцож 3,808.5 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1; 13.7 дугаар заалт " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг Сангийн сайдын "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2018 оны 301 дүгээр тушаалыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ХХААХҮЯ-ны ТЭДС-гийн ХАА-н бага оврын трактор худалдан авах төслийн гүйцэтгэх захирал В.Үнэнбат, ерөнхий нягтлан бодогч Б.Сосорбарам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР  Ч.ДАШДАВАА
"Б ЭНД С АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР  Д.ЗАЯАЖАРГАЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ХХААХҮЯ-НЫ ТЭДСАНГИЙН ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАГА ОВРЫН ТРАКТОР
ХУДАЛДАН АВАХ ТӨСЛИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  В.ҮНЭНБАТ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Б.СОСОРБАРАМ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

